

## Өмнөх үг

# Социализмын дараах Монголчууд

Брюс М. Кнауфт

Орчин цагийн Монгол орон бол эрчимтэй хөгжлийн “уурхай” болоод байгаад эргэлзэх хүн гарахгүй биз ээ. Эдийн засгийн огцом өсөлт хөл алдуулам их хэмжээний баялгийг шинээр бий болгож байхад өвдөг сөхрөм ядуурлын хэмжээ буурахгүй өндөр хэвээр байна. Эрдэс олборлолтоос орж ирж байгаа ашиг дэд бүтцийн салбарт цутгасаар байгаа хэрнээ нийслэл хотын зам дээр машины урсгалууд орооцолдон түгжирч байхад өргөн уудам бэлчээр нутгийн ачаар Монгол дэлхий дээр хамгийн сийрэг суурьшилтай улс орон гэсэн байр сууриа хадгалсаар байна. Өвөлдөө онгон байгальтай “мөнх хөх тэнгэрийн орон”-ы хот, суурин газрууд агаарын бохирдолдоо “хахаж” байхад хөдөө орон нутагт хахир өвлийн хайрах хүйтэн, зуд турхан олон тооны мал хорогдуулж, малчин өрхийн амьжиргааг хүндрүүлэх шалтгаан болно. Байгаль орчны доройтол энд байнгын аюул занал болжээ. Харин улс орон, хүн ардын ирээдүй тийм ч тодорхойгүй байгаа энэ нөхцөлд хамгийн гайхалтай зүйл бол монгол хүний бардам зан, эрх хүч, уян хатан чанар юм.

Харин улс төр, соёлын хувьд Монгол улс тодорхойлоход амаргүй байдалд байна. Хязгааргүй эрч хүчтэй хэрнээ дур зоргоороо мэт хөгжиж байгаа чөлөөт зах зээлийн харилцаатай ардчилсан Монгол улс бол автократ хоёр их хүчний хооронд хавчуулагдан хойд талдаа Орос, өмнө талдаа Хятадад “хашигдсан” далайд гарцгүй гуравхан сая хүнтэй улс орон юм. XX зууны далан жилийн туршид энд тогтсон ЗХУ-ын ноёрхлын түүхэнд Сталинч харгис хэлмэгдүүлэлт, бурханы шашин, соёлыг системтэйгээр устгах бодлого ч багтана. Одоо пост-социалист эрх чөлөөт үндэстэн болсон Монголчууд жавхаа-

тай, амжилттай, ирээдүйдээ тэмүүлэхийн зэрэгцээ мөн саяхны болон өнө эртний түүхийнхээ гүн гүнзгийн нөлөөг хадгалсаар яваа хүмүүс юм. Хамгийн наад захын жишээ бол 800 жилийн өмнө Чингис хааны байгуулсан Их эзэнт гүрэн, түүнээс ч өмнөх түүхээс улбаатай үндэсний их бахархал юм.

Монголчууд өөрсдийнхөө болон улс орныхаа шинэ төрх, хэлбэр, ухамсрыг нийгэм, эдийн засаг, улс төр, шашны салбар, чиглэлд хэрхэн бий болгож байна вэ? Нэн нарийн төвөгтэй ч гэлээ энэ асуулт зөвхөн Монголчуудын хувьд чухал болоод зогсохгүй орчин үеийн дэлхий ертөнц даяарх хүний хөгжлийн үйл явц, үр дүнг ойлгох түлхүүр болох юм.

Ихэнх тохиолдолд энэ асуултын хариултыг гаргаж авахын тулд нөлөөлөгч хүчин зүйлсийг нэг нэгээр нь салган авч байгаад, дотор нь үзэл бодлууд, сэдвүүд болгон задалж үздэг билээ. Бодлогын судалгааны тайлан, сэтгүүл зүйн нийтлэл, стратегийн дүн шинжилгээ нь академик болон эрдэм шинжилгээний ойлголт хандлагаас ялгаатай. Нэг талаас “улс төрийн” асуудлуудыг “эдийн засгийн” асуудлуудаас салгаж харах ёстой бөгөөд бүр цаашилбал, нөгөө талаасаа “соёлын” юмуу “шашны” асуудлуудаас салгах ёстой. Үүнтэй нэгэн адилаар, тогтмол өөрчлөгдөж байдаг амьдралын өсөн нэмэгдэж буй хурдыг ойлгох хүсэлдээ хөтлөгдсөн судлаачид өнөөдрийг түүхээс салгах буюу тусгаарлаж харахыг хичээдэг. Түүх ч мөн өөрөө дотроо олон давхаргатай. “Монгол” хэмээх үндэсний ухамсар, ижилсэлийн түүхэн хүчин зүйлс болон өнөөгийн төлөвшил, амьдралын бүхий л салбарт нэвт шингэсэн, далан жилийн Зөвлөлтийн хүчтэй хяналтын өв, хэдхэн жилийн өмнө л Монголчуудын мөрөөдөж ч зүрхлэхээргүй нээлттэй капиталист хөгжлийн бүс нутгийн, цаашлаад бүр дэлхийн хэмжээний амжилт, хөгжлийн нэн шинэ түүх.

Тэгвэл хүч хүрэхгүй хэт том зорилго, хүсэлдээ хөтлөгдөлгүйгээр, мөн холбоо хамааралтай хэсэг бүлгээр биш салангид тусгайрлагдсан нэгж болгох гэж зүтгэхгүйгээр эдгээр

хувирал өөрчлөлтийн утга учир, мөн чанарыг хэрхэн судлан ойлгож болох вэ?

Эдгээр асуултад хариулт олоход энэхүү судалгааны боть бага боловч чухал хувь нэмэр болно гэж бид найдаж байна. Монголын эдийн засаг, улс төр, соёл, шашин, түүх болон цаашдын хөгжлийн төсөөлөл зэрэг чухал асуудлуудыг хөндсөн өргөн хүрээтэй энэхүү боть нь салангид нэгжүүдийн үржигдэхүүн бус харин динамик бүхэллэгийг дүрслэн харуулахыг зорьж байгаа юм. Энэ номд барууны болон Монголын онол, шинжилгээг хослуулсны зэрэгцээ нийтлэл, өгүүллүүдийг янз бүрийн мэргэжлийн хүмүүсийн бичсэн юм. Ингэхэд өндөр түвшний төрийн албан хаагч, АНУ-ын элчин сайд, бурханы шашны лам хувраг, бөө, христийн номлогч, Монголын болон барууны чадалтай эрдэмтдийн бичсэн хурц нийтлэлүүдийг нэгтгэсэн сонирхолтой номыг та хэзээ хамгийн сүүлд уншсан бэ? Олон зохиогчийн бүтээлийг ийнхүү багцалсан нь холбоо хамааралгүй зүйлсийн тохиолдлын цуглуулгаас хавьгүй сонирхолтой үр дүн авчирна гэж бид найдаж байна. Өгүүлэл нэг бүр нь Монголчуудын үндэсний ухамсар/ ижилсэл, Монголын хөгжлийн тэргүүлэх зорилтууд, капиталист харилцааны сорил бэрхшээл, боломж давуу тал, өнө эртний болон саяхны үндэсний болон шашны түүхийн өв, нөлөөний тухай харилцан холбоотой асуултуудыг нухацтай авч үзэж байгаа юм.

Энэ номын суурь болсон бага хурал дээр оролцогчид идэвхтэй харилцан ярилцаж байсан шиг номонд багтсан өгүүллүүд мөн бие биентэйгээ “ярьж” байгаа мэт. Бага хурлын оролцогчдын хооронд тогтсон ажил хэрэгч холбоо харилцаа, итгэл бүрийн араас өрнөсөн халуухан хэлэлцүүлэг зэргээс мэдрэгдэж байсан эрч хүч, уур амьсгалыг үгээр дамжуулах аргагүй санагдаж байна. Монголын бурханы шашны тэргүүн, Станфордын их сургуулийн судлаач, шашны асуудлыг төрийн хэргээс салгах ёстой гэсэн бодолтой явдаг Монгол залуутай

ихэд хүндэтгэсэн байдалтай тун удаан ярилцав. Үндэсний хөгжлийн хорооны тэргүүн оройн хоолны үеэр болсон хэлэлцүүлэгт ажлынхаа дараа дахин ирж, эрдэмтэн судлаач, иргэний нийгмийнхэнтэй удаан ярилцаж суув. Монголын түүх, соёлын тухай олон мэтгэлцээний үеэр Зөвлөлтийн үеийн үзэл суртал, хяналтын сүүдрийн дундаас одоо л ил гарч ирж байгаа баримт факт, байр сууриуд илэрч байсан юм.

## **Номын зохион байгуулалт**

Ялгаатай эдгээр хандлага, асуудлуудыг уншигчдад хүргэхийн тул уг номыг 4 бүлэг болгон зохион байгууллаа. Таны уншиж буй энэхүү Удиртгал хэсгийн араас социализм задран унасны дараахан 1990-ээд оны эхээр Монгол “эрсдэлд өртсөн төр” байсан тэр үеэс хойшхи Монгол улсын хөгжлийн тойм дүн шинжилгээг танилцуулна. Энэ тойм дүгнэлтэд орчин цагийн Монголын улс төр, эдийн засаг, соёлын хөгжлийн өвөрмөц сорил бэрхшээл болон боломж, давуу талуудыг дүрслэн харуулахыг хичээлээ. Монголын нийгмийн бодлого, тогтвортой улс төрийн хөгжилд хувь нэмэр болох үүднээс тойм шинжилгээний практик дүгнэлтүүдийг зөвлөмж хэлбэрээр томъёолсон болно.

Номын эхний хэсэг болох “Засаглал, эдийн засагт учирч буй сорилт, баялгийн тэгш бус байдал” сэдэвтэй тэргүүн бүлэгт АНУ-ын Элчин сайд, Монголын Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дарга, Монгол улсын Ерөнхийлөгчийн Аюулгүй байдлын зөвлөх, нийгмийн шинжлэх ухааны нэр хүндтэй эрдэмтэн, Монголын алслагдсан хөдөө нутагт угсаатан зүйн хээрийн судалгаа хийсэн АНУ-ын нэгэн их сургуулийн судлаач зэрэг хүмүүсийн өгүүлэл багтаж байгаа юм. Эдгээр өгүүлэл нь эдийн засгийн хурдацтай өсөлт, идэвхтэй ардчилсан үйл явц, асар их хэрнээ улам нэмэгдэж буй хөрөнгө чинээний ялгааны дунд орчин цагийн Монгол орны өмнө бодитойгоор

тулгараад байгаа гүн гүнзгий сорил бэрхшээл, асар их боломжуудыг харуулж чаджээ. Эдгээр нь Монголыг чинээлэг, эрх чөлөөтэй, тогтвортой улс болж хөгжихөд шийдвэрлэх биш юмаа гэхэд хүчтэй нөлөө үзүүлэх чухал асуудлууд юм.

Номын дараагийн бүлэгт “Орчин үеийн шашны асуудлууд”-ыг авч үзнэ. Энэ бүлэгт бид монгол бөө, Христийн номлогч, Монголын бурханы шашин судлалын нэр хүндтэй гадаадын судлаач, одоо АНУ-д амьдарч байгаа Монголын бурханы шашны эрхэм дээд хутагт, Улаанбаатар хотоос холгүй бурханы шашны томоохон цогцолбор байгуулах ажлыг удирдан хэрэгжүүлж байгаа шашны өндөр боловсролтой судлаач, Зөвлөлтийн үзэл суртлын хяналтын үеэр устгагдсан сүм, хийдийг сэргээхэд үнэтэй хувь нэмэр оруулж яваа лам зэрэг хүмүүсийн байр суурийг багтаалаа. Номын эхний бүлэгт авч үзсэн улс төр, эдийн засгийн асуудлууд нь үндэсний нийгэм-эдийн засгийн хөгжлийн суурь, дэмжигч хүчин зүйл болж байдаг соёлын болон хувь хүний үнэт зүйлстэй холбоотой байдаг шиг шашин, шүтлэг ч мөн үндэсний ухамсар, ижилсэл болон үндэсний нийгэм, соёлын хөгжлийн асуудлуудтай шууд холбоотой болох нь илт мэдрэгдэнэ.

“Нийгэм, соёлын хөгжил” нэртэй гуравдугаар бүлэг нь Монгол үндэсний ухамсар буюу ижилслийг түүхэн хөгжлийн явцад хэрхэн бий болгож ирсэн, мөн орчин үеийн нийгэмд хэрхэн нээж, дахин бий болгож байгаа асуудлыг авч үзлээ. Энэ бүлэгт Монголын түүх, соёлын нэртэй судлаач Кембрижийн их сургуулийн профессор, хорь гаруй номын зохиолч одоо Монголын томоохон төрийн бус байгууллагын захирал, Монголын Ажил олгогч эздийн холбооны Хөдөлмөрийн харилцаа хариуцсан хэлтсийн тэргүүн зэрэг хүмүүсийн өгүүлэл багтсан болно. Орчин үеийн Монголчуудын буй болгож байгаа институци, бүтцүүд, үндэсний ухамсар ч гэсэн зорилготой үйл ажиллагаа, байнгын хувьслын чухал хүчин зүйл байсаар ч ирсэн, одоо ч байсаар байна.

Номын төгсгөлийн бүлэг болох “Бурханы шашны өв, соёлын түүх” хэсэг нь Монголын өнөөгийн болон цаашдын хөгжлийн сонголтуудад нөлөөлөх Монголчуудын шашин, соёлын түүхийн асуудлуудад төвлөрч байгаа юм. Энэ хэсэгт өгүүлэл нь багтсан зохиогчдыг нэрлэх юм бол дэлхийн Төвд, Монголын бурханы шашин судлалын нэр хүндтэй судлаач, Америкийн монголч эрдэмтэн, Зөвлөлтийн хяналт нөлөөллийн үеийн Монголын соёл, шашны холбогдолтой дурдатгалуудыг судалдаг Будапештийн нэгэн их сургууль болон Монголын Шинжлэх Ухааны Академийн докторантууд, Буриад дахь бурханы шашныг судалдаг Москвагийн Их сургуулийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, Монголын Шинжлэх Ухааны Академийн Олон улс судлалын хүрээлэнгийн тэргүүн юм. Зөвлөлтийн хараа хяналтын дор Монголын түүхийг үзэл сурталжуулан, тодорхой зорилгын үүднээс тайлбарлан заадаг байсныг санах юм бол Монголын түүх, соёл, шашныг шинэ нүдээр харах гэсэн энэхүү оролдлого нь Монголчуудын өнөөгийн болон дараа дараагийн үеийн үндэсний ухамсар, ижилслийг бүрдүүлж өгөх тул онцгой чухал асуудлууд юм.

Уг ботийн шинэлэг тал, утга санааг уншигчдад илүү сайн ойлгуулах үүднээс өгүүлэл бүрийн эхэнд товч өмнөтгөл оруулж өглөө. Эдгээр тайлбар нь өгүүлийг танилцуулах, өргөн контекст дотор тухайн бүтээлийн эзлэх байр суурийг тодорхойлж өгөх юм. Ийм ч учраас эдгээр өмнөтгөл нь уншигчдыг тухайн сэдэв рүү гүн гүнзгий орж, агуулгын мөн чанар луу нэвтрэхээс өмнө сэдвийн холбогдолтой чиглүүлэг болох зорилготой болно.

## **Нөхцөл байдал ба ач холбогдол**

Өмнө дурьдсанчлан, уг ном нь 2011 оны 6 дугаар сарын 27-29-ний өдрүүдэд Улаанбаатар хотод Нээлттэй Нийгэм Форум төрийн бус байгууллагын байранд зохион байгуулагдсан “Социализмын дараах Монголчууд” хэмээх ижил нэртэй

томоохон хурлын оюуны болон практик бүтээгдэхүүн юм. Энэ ном, мөн Бага хурал нь ялгаатай олон үзэл баримтлал, байр сууриудыг хамарсан өргөн хүрээтэй бүтээлч хамтын ажиллагааны үр дүн юм. Анхдагч санаа, дэмжлэгийн ихэнх хэсгийг Атланта хотын Эмори Их сургууль дээр миний удирдан хэрэгжүүлж буй “Бүс нутгийн эрсдэл өртсөн улс орнууд” (States at Regional Risk Project буюу SARR) төслөөс гаргасан. Нью Йоркд байрлах Карнеги Корпорацийн дэмжлэгээр хэрэгжиж байгаа олон жилийн энэхүү төсөл томоохон нийгэм-улс төрийн шилжилт, эрсдлийг туулсан улс орон, бүс нутгийн бодлого боловсруулагч, иргэний нийгмийн зүтгэлтэн, дотоод гадаадын экспертүүдийн хооронд яриа хэлэлцүүлэг өрнүүлэх зорилготой юм.

“Бүс нутгийн эрсдэлд өртсөн улс орнууд” буюу SARR төслийн бүсийн түвшний төслүүд нь, жишээлбэл, Баруун Африк, Зүүн Африкийн удаан үргэлжилсэн иргэний дайн, улс төрийн тэмцэл, нийгэм-соёлын хямралын дараа улс орноо сэргээх амаргүй зорилтыг хэрэгжүүлж байгаа бүс нутаг, улс орнуудад ажиллаж байна. (Тодорхой мэдээллийг SARR төслийн [sarr.emory.edu](http://sarr.emory.edu) хаягаар байрлах веб хуудаснаас авна уу.) Эдгээрээс ялгаатай нь Монголд харин Зөвлөлтийн хатуу нарийн хяналт, дараа нь чөлөөт эдийн засгийн харилцаанд шилжих хүнд бэрх шилжилт зэргээс эхтэй нийгэм, улс төрийн хямралууд нь одоо эдийн засгийн хурдацтай өсөлт, ардчилсан засаглалаар солигджээ. Зарим талаараа Монгол улс нь нийгэм, улс төр, эдийн засгийн эрс өөрчлөлтийг амжилттай даван туулаад, автократ тогтолцоотой, түрэмгий бодлоготой супер хүчнүүдээр хүрээлэл дунд байдаг ч харьцангуй утгаараа сэргэн хөл дээрээ зогсож, амжилттай хөгжиж байгаа улсын эерэг жишээ болж байгаа юм.

Хүсэмжилж буй хөгжил цаашид ч тогтвортой үргэлжлэх баталгаа байхгүй ч Монгол бол нийгэм-эдийн засгийн хийгээд улс төрийн хүчтэй давалгааны дараа хөгжлийн олон үзүүлэлтээ

нэлээдгүй ахиулж чадсан улс орны жишээ мөн. Энэ талаараа Монгол улс төв Ази, мөн Сахарын бүсийн Африкийн орнууд, Ойрхи Дорнодын олон улс, бүс нутгаас илүү байгаа юм.

Монгол улс хөгжлөө дэмжихэд ашиглаж болох эрдэс, уул уурхайн бүтээгдэхүүний арвин их бөгөөд баялаг нөөцтэй нь түүний давуу тал боловч зөвхөн үүгээр энэ орны сэргэн мандалт, хөгжлийн өвөрмөц зам мөрийг тайлбарлах аргагүй. Арвин их байгалийн баялаг нь нийгэм-эдийн засаг, улс төрийн хөгжил дэвшлийн баталгаа болж чаддаггүйг Нигериас авахуулаад Конго (Бүгд Найрамдах Конго Улс), Сиерра Лионе, Ирак, Афганистан зэрэг улсын жишээ бэлхнээ харуулж байна. Эсрэгээрээ, байгалийн нөөцөөс орж ирэх гэнэтийн ашиг нь өмнөд Конгогийн (SARR төслийн ажилладаг бүс нутаг) эрдэс, баялаг ихтэй бүс нутгуудад хэдэн арван жилийн туршид арилахгүй үргэлжилсээр байгаа “баялгийн хараал” буюу төрийн эрх мэдэл нэг хүний гарт төвлөрсөн автократ тогтолцоо, авилга, хөрөнгө баялгийн давхраажсан тэгш бус байдал, цаашилбал иргэний дайн, нийгмийн үймээн хямрал” болж хувирах магадлалтай.

Байгалийн баялгаас олох орлогоор нийгэм-эдийн засгийн хямралын дараах сэргэлт, хөгжлийг засах гэж оролдох нь өрөөсгөл бөгөөд үүнд нийгмийн институцууд, мөн үнэт зүйлсэд суурилсан нийтийн ухамсар буюу ижилсэл (нэг үгээр бол соёлын) гүйцэтгэх чухал бөгөөд голлох үүрэг ролийг харгалзан үзэх ёстой. Эмпирик хэмжүүрүүдээр нарийн бөгөөд тодорхой хэмжин, тодорхойлоход хүндрэлтэйн дээр цаг хугацааны явцад байнга өөрчлөгдөж, соёлын чиг баримжаа нь нийгмийн байгууламж, институцийн боломж, улс төрийн түүхэн туршлага, мөн эдийн засгийн нөөц, бололцоотой харилцан нөлөөлөлд орж, улс орны хөгжлийн ирээдүйд нөлөөлж байдаг гол тулгуур элемент юм. Энэхүү нэн чухал зүйлийг үндэсний болон бүс нутгийн хөгжлийн талаарх ойлголт, хандлагуудад дутуу үнэлэх, бүрмөсөн орхигдуулж байгаа нь анзаарагддаг.



Дээр дурьдсачлан, эдгээр асуудлыг судлахдаа эдийн засгийн болон нийгэм юмуу түүхэн шинжилгээ гэж салгаж үзэх хандлага давамгайлж байгаа билээ.

Үүнийг залруулахын тулд “Социализмын дараах Монголчууд” нэртэй манай энэхүү төсөл анхнаасаа л эдгээр дотоод харилцан хамааралтай чиглэлийг зөвхөн зарчмын ойлголт, сэдвүүдийн хүрээг тогтооход харгалзаад зогсохгүй үзэл хандлага буюу тодорхой асуудлаар баримтлах байр сууриудын харилцан бие биенээ нөхөж буй байдлаар гаргаж ирэхэд онцгой ач холбогдол өгч хандсан юм. Өрнийн эрдэмтдийн боловсруулан гаргасан онолын буюу академик хандлага, ойлголтууд нь орчин цагийн Монголын ээдрээтэй амьдралын нарийн ширийнийг сайн тусгаж чадахгүй бөгөөд энэ нь Монголчуудаас өөрсдөөс нь гарч ирэх мэдлэг юм. Үүнд тодорхой асуудлаар дагнан ажилладаг Монгол мэргэжилтнүүд, иргэний нийгмийн идэвхтэн, судлаачид, мөн мэргэжлийн нарийн хүрээнд баригддаггүй хөндлөнгийн бие даасан судлаач, ажиглагчдыг багтааж байгаа юм.

## **Төслийн зохион байгуулалт ба талархал**

Төслийн хүрээнд анх 2010 онд Монголд томилолтоор ажиллах явцдаа би дээрх асуудлуудаар Монголын олон байгууллага, хувь хүн, төрийн байгууллагын ажилтан, Азийн сан, Америкийн Монгол судлалын төв, АНУ-ын Элчин сайдын яам, Монгол улсын их сургууль, Монголын Шинжлэх ухаан технологийн Их сургууль болон Гаалийн сургуулийн багш, захиргааны ажилтан, бурханы шашны тэргүүнүүд болон иргэний нийгмийнхнээс тодорхой мэдээлэл, харамгүй зөвлөгөө авсан юм. Эдгээр байгууллага, хүмүүст бүгдэд нь гүнээ талархаж байна. Эдгээрээс Улаанбаатар хотод байрлах Нээлтэй Нийгэм Форум (ННФ)-ын Нийгмийн бодлого, боловсролын хөтөлбөрийн менежер Амгаабазарын Гэрэлмаатай ажил хэргийн холбоо тогтоосон нь төслийн үйл ажиллагаанд онцгой чухал явдал болсон юм.

ННФ “Бүс нутгийн эрсдэлд өртсөн улс орнууд” буюу

SARR төслийг анхнаасаа ихэд сонирхож, ялангуяа академик, иргэний нийгмийн болон бодлогын байр сууриудыг “уулзуулах”, тэр дотроо ардчилсан засаглал нийгэм-эдийн засгийн хөгжил, боловсрол, байгаль орчны холбогдолтой сэдвүүдээр өргөн төлөөлийг хамруулан санал солилцох боломжийг онцгойлон сонирхсон билээ. Монголын институт, нийгмийн лидерүүдтэй холбоо сайтайн дээр тэдний дунд өндөр нэр хүндтэй ННФ нь манай төслийн Монгол дахь гол гүүр болсон юм. ННФ эмпирик болон стратегийн судалгаа, шинжилгээгээр дамжуулан практик түвшний, бодлогын үр нөлөө үзүүлэх зорилго тавин хавсарга судалгаанд төвлөрөн ажилладаг нь манай төслийн олон талыг холбох, байр сууриудыг хослуулах зорилготой нийцэж байлаа. Богино хугацаанд ННФ манай төслийн түнш байгууллага болж, Улаанбаатарт зохион байгуулсан бага хурлын зохион байгуулалтыг хариуцан ажилласан бөгөөд гурав хоногийн хурлыг өөрийн байранд явуулсан юм. Эдгээр болон бусад олон талын туслалцаа үзүүлэн ажилласан Амгаабазарын Гэрэлмаад бид онцгойлон талархал илэрхийлж байна.

ННФ-ын тусламжтайгаар бид Бага хурлын 3 хоногийн туршид Монгол, Англи, зарим үед Орос хэлний синхрон орчуулгатай ажилласан бөгөөд үүнд мөн илтгэлүүдийг дагаж өрнөсөн урт хэлэлцүүлгүүд багтаж байгаа юм. Синхрон орчуулга нь оролцогчдын хэлний болон харилцааны саад тотгорыг арилган, хэл, мэргэжил, боловсролын ялгааг даван нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлэхэд хамгийн чурал хүчин зүйл болж чадсан юм. Үүний ачаар ил тод, нээлттэй харилцаа өрнөж, хурал дээр тавигдсан илтгэлүүд хэлний бэрхшээлийг амжилттай даван туулж чадсанд бид тун баяртай байна. Энэ бүхний үр дүнд уг ном Монгол, Англи хэл рүү орчуулагдан, хоёр хэл дээрх ботиудад бүх өгүүллийг багтаах боломж олгосон билээ.

Эцэст нь, төслийг санаачлан, хэрэгжүүлэх ажлын нэгэн чухал хэсгийг Амхерст хот дахь Массачусеттсийн их

сургуулийн доктор Ричард Таупиер чадварлагаар гүйцэтгэсэн юм. Захиргааны өндөр албан тушаал хашихын зэрэгцээ Монголын түүх, бурханы шашныг сонирхон судалдаг эрдэмтэн хүн тул доктор Таупиер энэхүү үйл ажиллагааны бэлтгэлд анхнаасаа идэвхтэй оролцон, Бага хурлын соёлын, шашны болон түүхэн хамрах хүрээг тэлэн өргөжүүлэхээс гадна зохион байгуулалт, агуулгын бүхий л асуудлаар хамтран ажилласан билээ. Судлаач Гленн Х. Муллины дэмжлэг, Монголд тогтоосон ажил хэргийн холбооны тусламжтайгаар доктор Таупиер мөн Монголын бурханы шашны тэргүүнүүд, шашны болон түүх судлалын эрдэмтдийг Бага хуралд илтгэгч, оролцогчоор хамруулж чадсан бөгөөд үүний тулд Нью Йорк дахь Рубины сангаас санхүүгийн нэмэлт дэмжлэг авах нөхцлийг хангаж өгсөн юм. Энэ дашрамд, Рубины санд талархал илэрхийлье. Өөрөө хамтран зохион байгуулагчаар нь ажилласан манай төслийн үргэлжлэх бүхий л хугацаанд доктор Таупиер чухал бөгөөд ач холбогдолтой зөвөлгөө өгч байсан нь төслийг амжилттай хэрэгжүүлэхэд ихээхэн хувь нэмэр болсон юм. Доктор Таупиер энэхүү номын редактораар ажилласныг дурьдах хэрэгтэй.

Энэ номын Англи болон Монгол ботийг бэлдэн хэвлэх ажлыг Улаанбаатар хотод хариуцан ажилласан Пүрэвжавын Лхамд мэргэжлийн өндөр түвшинд шуурхай бөгөөд нарийн мэдрэмжтэй ажилласанд онцгой талархал илэрхийлж байна. П.Лхам Монголын Шинжлэх ухааны академийн Түүхийн хүрээлэнгийн судлаач юм. П.Лхамын хөдөлмөрч, тууштай хүчин чармайлтын ачаар л энэ ном гарч байгааг тэмдэглэх хэрэгтэй. Атланта хотын Эмори Их сургуулийн талаас SARR төслийн хөтөлбөрийн туслах Хелен Симмонс мөн адил гол үүргийг гүйцэтгэсэн бөгөөд төслийн ерөнхий зохион байгуулалтыг бүрэн хариуцан ажилласан юм.

Энэ номын хэвлэн нийтлэлд Монголын Шинжлэх Ухааны Академи (ШУА), Монгол Улсын Их сургууль (МУИС),

Нээлттэй Нийгэм Форум (ННФ) хамтран оролцож байгааг дурьдахад таатай байна. Хамтарсан хэвлэн нийтлэлийг ШУА-ийн зүгээс Түүхийн хүрээлэн, түүний захирал доктор Сампилдондовын Чулуун, мөн Олон улс судлалын хүрээлэн, түүний захирал доктор Лувсангийн Хайсандай дэмжиж байгаа билээ. МУИС-ийн талаас манай Бага хурлыг нээж үг хэлсэн ректор доктор Санжбэгзийн Төмөр-Очир, МУИС-ийн Нийгэм, Соёлын Антропологийн тэнхим, түүний эрхлэгч доктор Дуламын Бум-Очир нар дэмжсэн болно.

Улаанбаатар хотод SARR төслийн хүрээнд зохион байгуулсан “Социализмын дараах Монголчууд” бага хурлыг нээж мөн Монгол улсын Шинжлэх ухаан технологийн их сургуулийн ректор доктор Баяндүүрэнгийн Дамдинсүрэн, Монголын бурханы шашны тэргүүн хамба лам Чойжамц нар үг хэлсэнд бид нэн талархалтай байна. Салбар хуралдаануудыг даргалж оролцсон болон хэлэлцүүлгийг удирдан явуулсан хүмүүс талархал илэрхийлж байна. Мөн энэхүү хурлын бэлтгэл шатанд мэргэжлийн хүмүүстэй холбоо тогтооход туслалцаа дэмжлэг үзүүлсэн Гаалийн дээд сургуулийн ахлах багш асан Жавчивдоржийн Булганд талархал илэрхийлье. Бага хуралд илтгэл тавьж оролцсон зарим хүн тодорхой шалтгааны улмаас нийтлэл, өгүүллээ энэ ботид оруулж чадаагүй ч хурлын үеэр тэд яриа хэлэлцүүлэгт идэвхтэй оролцсоныг тэмдэглэх хэрэгтэй. Хурлын дараа Тэрэлжид хийсэн нэг өдрийн уулзалтад оролцон, хурлын талаарх үнэлгээ дүгнэлтээ хуваалцсан Ойдовын Энхтуяа (The Nature Conservancy байгууллагын захирал, Нээлттэй Нийгэм Форумын Удирдах зөвлөлийн гишүүн), доктор Ричард Таупиер, доктор Даниел Ж.Мёрфи, Амгаабазарын Гэрэлмаа нарт талархал илэрхийлье. ННФ манай төслийн хувьд олон талын чухал үүрэг роль гүйцэтгэсэн бөгөөд уг ном энэ байгууллагаас хэвлэн гаргасан олон ном, тайлангийн тоог нэгээр нэмэгдүүлж байгаад баяртай байна.

Улаанбаатар хотод байрлар АНУ Элчин сайдын яам

нь эрхэмсэг Элчин сайд Жонатан Аддлетоны удирдлага дор төслийн хэрэгжилтэд ихээхэн дэмжлэг үзүүлсэн юм. Элчин сайд Аддлетон Бага хурлыг нээж үг хэлээд зогсохгүй сонирхолтой сэдвээр бүрэн хэмжээний илтгэл тавьсныг өгүүлэл хэлбэрээр энэ номонд орууллаа. Мөн эрхэмсэг Элчин сайд 2011 оны 6 дугаар сарын 21-ний орой өөрийн гэрт хурлын оролцогчдыг хүлээн авч, оройн зоог барьсан явдалд мөн гүнээ талархаж байна.

Бага хуралд урилгаар оролцож илтгэл тавьсан хүмүүсийн дотор Үндэсний аюулгүй байдлын асуудлаар ажилладаг зөвлөх, үндэсний хэмжээний төлөвлөлт хариуцсан төрийн байгууллагын тэргүүн, Их Хурлын гишүүн, АНУ-аас Монгол улсад суугаа Элчин сайд, Монголын үндэсний хоёр том их сургуулийн захиралууд, Монголын бурханы шашны тэргүүн, шашны болон христийн шашны 5 зүтгэлтэн, Монголын иргэний нийгмийн 4 төлөөлөгч, Монголын нэр хүндтэй 5 эрдэмтэн, гадаадын Монголч 9 эрдэмтэн байв. 8 орныг төлөөлж ирсэн эдгээр оролцогч Монголчуудыг бүс нутгийн хэмжээнд гадаад ертөнцөнд төлөөлөх хүмүүс юм. Бодлого боловсруулагч, иргэний нийгмийн идэвхтэн, эрдэмтэн судлаачдын нэгэн дор цуглуулж, чухал асуудлуудаар хэлэлцүүлэг, харилцан яриа өрнүүлэх нөхцлийг ханган, нэгдсэн ойлголтыг бий болгож чадсанаараа энэхүү Бага хурал маш амжилттай үйл ажиллагаа болохын зэрэгцээ Өвөр Азийн бүс нутгийн асуудалд төвлөрсөн өвөрмөц арга хэмжээ боллоо.

Дээр дурьдсан хүмүүс тус бүртээ зөвхөн тодорхой нэг салбар хуралдаанд илтгэгч, хуралдаан даргалагчаар оролцоод зогсохгүй бага хурлын бусад салбар хуралдаанд идэвхтэй оролцон оролцож, өөрсдийн байр суурийг илэрхийлэн хэлэлцүүлэгт үнэтэй хувь нэмэр оруулж байсныг бид талархан онцолж байна. Энэхүү үйл ажиллагаанд хүмүүс үнэн сэтгэлээсээ хандаж, ихэд сонирхож оролцсоны нэг жишээ бол хааны бөө Түвшинтөгс хурлын үеэр гэнэт эмнэлэгт

хэвтэх болсон тул өөрийн илтгэлийг бүрэн хэмжээгээр хэлж бичүүлснийг гараар тэмдэглэж авсан бие төлөөлөгч нь Бага хурал дээр уншиж танилцуулсан явдал юм. Улмаар энэхүү гар бичмэлийг бид компьютерт оруулан уг номын Монгол болон Англи ботиудад багтааж байна. Идэвхтэй оролцоо, бүтээлч шүүмжлэл, төр, иргэний нийгэм, эрдэм шинжилгээ, шашны салбарын төлөөлөгчдийн бие биенээсээ суралцан мэдлэгээ тэлж байсан нь маш сонирхолтой, зарим үед бүр биширмээр эрч хүчтэй үйл явц болж байлаа.

Өгүүлэл, нийтлэлүүдийг эмхэтгэл болгох ажлыг гүйцэтгэхэд хамгийн их хөдөлмөр шаардсан хэсэг нь илтгэгчдээс өгүүлийг бичүүлж аваад, эхийг редакторлах ажил байдаг. Гэтэл энэ удаад өөр байсан юм. Зохиогчид маш идэвхтэй, хариуцлагатай ажиллан, илтгэлд өгсөн шүүмж, саналуудыг тусган өгүүллээ цаг хугацаанд нь бэлэн болгож өгсөн юм. Зохиогчдийн маань энэхүү идэвх, сонирхлын үр дүнд уг боть илүү баялаг, улам үнэ цэнэтэй болж чадсан гэж найдаж байна.

## Дүгнэлт

Ном, бүтээлийн удиртгал, танилцуулгад төслийн зорилго, зохион байгуулалтыг цаг үеийн нөхцөл байдал, талархлаас ялгаж, салангид хэсгүүд болгосон байх нь элбэг. Харин энэ номын хувьд эдгээр хэсэг нь бие биендээ нэвт шингэсэн нийлмэл зүйл юм. Өөрөөр хэлбэл, энэхүү номыг бүтээх үйл явц, арга хэрэгсэл нь түүний агуулгын салшгүй бүрдэл, мөн түүгээр дамжуулан хүргэх гэсэн гол санааны нэгэн хэсэг юм. Тулгамдсан асуудлууд, ялгаатай байр сууриуд, судлагдахууны талаарх илтгэгчийн өөрийн хандлага, цаг үеийн нөхцөл байдал зэргийг бүтцэд оруулан нэгэн бүхэл болгох хэрэгцээтэй нэгэн адилаар “агуулга” өөрөө орчин нөхцлөөс ангид, салангид оршиж байдаггүйг харуулахын тулд дээр дурьдсан зохион байгуулалт, бүтэц зэрэг илтгэлийн практик талуудыг нь харгалзах ёстой билээ.

Дэлхийн бүс нутгуудын хооронд болон доторх соёл, нийгэм, улстөр-эдийн засгийн хөгжлийн холбоо хамаарлыг сонирхон судалдаг антропологичийн хувьд би судлаачдын ялгаатай байр сууриудыг хүндэтгэхийг шаарддаг угсаатан зүйн мэдрэмжийг илүү өргөн хүрээтэй нэгдсэн ойлголт, мэдлэгийг бий болгоход тусалдаг аналитик арга зүйтэй хослуулах нь чухал гэдэгт итгэдэг. Энэ хамаарал бол стратегийн, эрдэм шинжилгээний болон практик ач холбогдлыг нэгэн зэрэг агуулж байгаа юм. Тодорхой хэлбэл, энэ хандлага нь мэдлэг, ойлголтуудын бие биенээ хязгаарлах, буулт хийхийг шаардах аспектиуд бус харин харилцан бие биенээ нөхөн гүйцэлдүүлэх талууд дээр нь тулгуурладаг. Энэхүү холбоосыг номын агуулга болон нийгэмд хэрэгтэй шүүмжит хийгээд ашигтай мэдлэг үйлдвэрлэх зорилгын хүрээнд нэгтгэн хүргэх нь энэ төслийн нэгэн чухал зорилт байлаа. Судлаач миний өөрийн салбарт үүнийг “оролцоонд суурилсан антропологи” гэж нэрлэдэг. Оролцоонд суурилсан антропологийн чиглэл нь мэдлэгийн эрдэм шинжилгээний болон практик буюу хэрэглээний аспектиудын уялдаа, холбоо хамаарлыг зөвхөн судлагдахуун гэж хараад зогсохгүй судлаачийн амьдралын хэвшил болгож судалгаандаа хэрэглэх гол арга зүй гэж үздэг билээ.

Энэхүү төслийн хамгийн чухал үр дүн бол хурдацтай өөрчлөгдөж буй улс орон, өмнө нь тулгараад буй сайхан боломж, хүчтэй сорилтуудынхаа талаарх Монголчуудын өөрсөддөө зориулсан мэдлэг, мэдээлэл юм. Социализмын дараах Монголчууд өөрсдийнхөө өнөө үеийг гардан босгохдоо соёлын болон нийгэм, улс төрийн өнгөрсөн үеэсээ сургамж авч, ирээдүйн зам мөрөө тодорхой төсөөлсөөр явна. Хэрэв уг боть энэ үйл явцад өчүүхэн ч гэсэн хэрэг болж, бодож боловсруулах, санал бодлоо солилцох, санаа авч чиглүүлэхэд бага ч атугай хувь нэмэр болж чадваас бидний зорилго биелэх билээ.

---

**ТАЙЛБАР:**

Энэхүү номонд багтсан материал, үзэл бодлыг аль болох өргөн хүрээнд түгээн дэлгэрүүлэх үүднээс Англи, Монгол хэл дээрх ботийн бүрэн агуулгыг pdf файл хэлбэрээр SARR төслийн веб хуудас дээр байршуулсныг [sarr.emory.edu/MAS](http://sarr.emory.edu/MAS) хаягаар орж үзнэ үү.

Номын талаарх санал, шүүмжийг цахим захидлаар Брюс Кнауф ([bruce.knauft@emory.edu](mailto:bruce.knauft@emory.edu)), Ричард Таупиер ([taupier@research@umass.edu](mailto:taupier@research@umass.edu)), Амгаабазарын Гэрэлмаа ([gerelmaa@forum.mn](mailto:gerelmaa@forum.mn)) нарт явуулж болно.